

11

АНГЛИ ХЭЛНИЙ ТОДОТГОЛ ГИШҮҮН ӨГҮҮЛБЭРИЙГ ОРЧУУЛАХ ТУХАЙ

Ц.Баярмаа

Монгол орон зах зээлийн харилцаанд шилжиж улс төр, эдийн засаг болон урлаг соёл гэх мэт бүхий л салбарт дэлхийн олон оронтой харилцах болсон нь төрөл бүрийн найруулгын зохиол бүтээлийг гадаад хэлнээс монгол хэл рүү, монгол хэлнээс гадаад хэл рүү хөрвүүлэх хэрэгцээ шаардлагыг нийгэмд зүй ёсоор бий болгосон байна.

Үүнтэй уялдан орчуулгын өдий төдий ном, зохиол болж буй чанаргүй орчуулгын тоо өдрөөс өдөрт олшиирсоор байна. Үүнд тухайн гадаад хэлийг төдийгүй тэр хэлээр ярилцагч ард түмний соёл, зан заншлыг дутуу дулимаг судлах, эх хэлээ муу мэдэх, сэтгэл зүтгэл дутах, хариуцлагагүй хандах, зөвхөн ашиг харах, магадгүй авьяас дутах гэх зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байгаа ч үүнд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйл нь доктор Б.Энхбаярын өгүүлснээр орчуулгын онолын судалгаа зогсонги байдалд орсон⁸ явдал юм. Үнэхээр ч манай орны хувьд хийгдсэн орчуулгын онолын судалгааг авч үзэхэд хуруу дарам хэдхэн эрдэмтний маань голдуу орос монгол хэлний хүрээнд уран зохиолын хэл найруулгын хувьд хийгдсэн судалгаа байна.

Өнөөгийн орчуулгын хэрэгцээ шаардлагыг анхаарч үзвэл төрөл бүрийн салбарын мэргэжлийн ном зохиол, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллэгийн чиглэлээр гадаад болон монгол хэл рүү орчуулга хийх эрэлт ихсэж байгаа нь мэргэжлийн ном зохиолыг гадаад хэл, ялангуяа англи хэлээр судлах явдал түгээмэл болсонтой холбоотой болов уу. Зарим их дээд сургуулиудад орчуулгын онол, дадлагын хичээл зааж байгаа ч багш нарт ашиглах материал дутагдалтай байна. Иймд орчуулгын онолыг аль болох олон хэлний

харьцуулсан судалгаагаар баяжуулах, орчуулга хийж буй тухайн хоёр хэлний тогтолцоо, хэлзүйн ялгаатай байдлыг нарийн тусгасан харьцуулсан судалгаануудыг хийх, орчуулгын онолын ном, гарын авлагуудыг

⁸ Орчуулгын онол практикийн тулгамдсан асуудлууд, Хурлын эмхтгэл, Өмнөх үг, 2007

боловсруулж олон нийтийн хүртээл болгох зэрэг нь хэлний салбарт тулгамдсан асуудлууд болоод байна.

Иймд, орчуулгад хэл зүйн хувиргалын аргыг хэрхэн хэрэглэх талаар хөндөхийг хичээлээ. Үүнд эдийн засгийн салбарын хувьд англи монгол хэлний хүрээнд жишээ авсан болно.

“Орчуулгыг зөв, оновчтой хийхийн нэг чухал шижим бол хоёр хэлний хэлзүйг сайн мэдэх явдал мөн. Ялангуяа аль хэлнээс орчуулах гэж байна, тэр хэлний хэлзүйн нарийн учир холбогдлыг орчуулагч хүн заавал мэдэх ёстой. Алив өгүүлбэрийн гишүүдийн байрлал, дэс дараа, үгийн хэлзүйн хэлбэрийг зөв олж тавихаас багагүй зүйл шалтгаална.” хэмээн Ц.Цэдэндамба “Орчуулгын үндэс” номдоо өгүүлжээ.⁹

Англи монгол хэлний өгүүлбэр бүтцийн хувьд нэлээд ялгаатай. Англи хэлний энгийн өгүүлбэр SVO буюу өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, тусагдахуун гэсэн байрлалтай байдаг бол монгол хэлний өгүүлбэр SOV буюу өгүүлэгдэхүүн, тусагдахуун, өгүүлэхүүн гэсэн байрлалтай байдаг нь энэ хоёр хэлний бүтэц тогтолцооны гол ялгаа юм. Иймд уг хоёр хэлний хооронд орчуулга хийхэд наад зах нь өгүүлбэрийн гишүүдийн байрыг солих аргыг хэрэглэх шаардлага гардаг.

Манай нэرت орчуулагч асан Д.Дашдаваа “Орчуулга хийхэд тулгардаг гол бэрхшээлүүдийн нэг нь дэлхийн олон хэлний тогтолцоо харилцан адилгүй байдаг явдал юм. Иймд нэг хэлнээс нөгөө хэл рүү орчуулахад хувиргалын аргыг хэрэглэх нь түгээмэл тохиолддог бөгөөд үүнийг орчуулгын онолын зүй ёсны үзэгдэл гэж бичсэн байна. Орчуулж байгаа өгүүлбэрийн утгыг алдагдуулалгүйгээр тухайн хэлний өгүүлбэрийн бүтцийг өөрчилж эх хэлнийхээ өгүүлбэрийн тогтолцооны дагуу найруулан буулгахыг хэл зүйн хувиргал хийж орчуулах гэж хэлнэ гэж Г.Аким “Орчуулгын санг уудлахад” зохиолдоо тодорхойлоод дараах хэлзүйн хувиргалууд байдаг гэсэн байна¹⁰:

- өгүүлбэрийн гишүүдийн байр солих
- өгүүлбэр нийлүүлэх
- өгүүлбэр салгах
- өгүүлбэрийн бүтцийг өөрчлөх
- солих
- орхих
- нэмэх

Эдийн засгийн бичвэрүүдийг англиас монгол руу орчуулахад нийлмэл болон хавсарсан нийлмэл өгүүлбэрүүдийн хувьд хүндрэл их гардаг. Ялангуяа, гол болон гишүүн өгүүлбэрийн уялдаа холбоо, эдгээр өгүүлбэрүүдийг холбодог холбоос үгийн үүргийг зөв ойлгох нь өгүүлбэрийн санааг зөв орчуулахад чухал үүрэгтэй байдаг.

⁹ Ц.Цэдэндамба, “Орчуулгын үндэс” УБ 1979, х. 15.

¹⁰ Г.Аким, “Орчуулгын санг уудлахад” УБ, 1984, х.37.

Гэхдээ хэлнүүдэд байдаг түгээмэл шинжүүд орчуулга хийж буй хоёр хэлний өгүүлбэрийн бүтэц, байгуулалтыг харьцуулах гол суурь болдог. Жишээ нь англи хэлэнд байдаг гишүүн өгүүлбэрүүд болох adjective clause, adverb clause, noun clause нь монгол хэлний тодотгол, байц болон тусагдахуун гишүүн өгүүлбэрүүдтэй үүргийн хувьд дүйж байдаг.

Adjective clause буюу тодотгол гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрийнхээ аль нэг нэр үгийг тодотгон угсруулах аргаар холбогдож, тодотгуулагч тодотгогчийн харилцаанд суурилж байдаг нь англи монгол хэлний хувьд төстэй байна.

Гэвч хэлзүйн хэлбэржилт нь өөр өөр байдаг. “Монгол хэлний тодотгол гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйлийн тодосгон холбох нөхцөл бүхий үйл үг, эсвэл харьцааны нэрээр илэрч, харьяалахын тийн ялгалаар, үндсээрээ, эсвэл *гэ+үйлийн* тодосгон холбох нөхцөл гэсэн хэрэглүүрээр хэлбэржин холбогддог.”¹¹

Англи хэлний adjective clause нь гол өгүүлбэртэйгээ захирах холбоос (subordinators) *who, which, that, whose, where* зэргээр холбогддог. Эдгээр холбоос нь тодотгол гишүүн өгүүлбэрийг гол өгүүлбэрийн тодотгуулагч үтгэй холbon, гишүүн өгүүлбэртэй ямар нэг гишүүний үүргийг гүйцэтгэдэг. Байрлалын хувьд тодотгуулагч үтгэйгээ ойр байдаг бөгөөд өгүүлбэрийн дунд, юмуу адагт байрлаж болдог. Харин монгол хэлэнд тодотгол гишүүн өгүүлбэр заавал тодотгуулагчийнхаа өмнө байрладаг нь тогтолцооны том ялгаа болно.

Эдгээр холбоос үгийн (*who, which, that, whose, where*) дүйцэл монгол хэлэнд байхгүй тул гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүний үйл үгийн хэлбэржилтээс хамааран ихэвчлэн үйлт нэрийн *-даг, дэг, дог, дог* зэрэг үйлийн давталт заасан нөхцөл, *-сан, сэн,сон,сон* зэрэг өнгөрсөн хэлбэр заасан нөхцөл, *-аа, ээ, oo, oo* зэрэг үргэлжилсэн хэлбэр заасан нөхцөл, *гэ+үйлийн* тодосгон холбох нөхцөл, эсвэл нөхцөлт үйлийн *-жс, -ч-* гээр төгссөн хэлбэрийн дараа орсон үйлт нэрийн хэлбэрээр дамжин орчуулагддаг.

Жишээ:

Wholesaling is part of the marketing system, which provides channels of distribution of goods to market.

Энд англи хэлний захирах холбоос *which* нь гол өгүүлбэр болох *wholesaling is part of the marketing system* –ийн тусагдахуун болох *part*-г төлөөлөн гишүүн өгүүлбэрт өгүүлэгдэхүүний үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд уг тодотгол гишүүн өгүүлбэр маркетингийн систем дэх “бөөний худалдаа” гэгч бүрэлдэхүүн хэсэг нь ямар үүрэг гүйцэтгэдэг болохыг тодотгож байна. Тодотгол гишүүн өгүүлбэр нь энэ жишээн дээр гол өгүүлбэрийн тусагдахууныг тодотгосон байна.

Одоо монгол хувилбарыг авч үзье.

¹¹ Д.Төмөртогоо, Б.Пүрэв-Очир нар, “Монгол хэлний сурх бичиг”, УБ 1998, х.139.

Бараа бүтээгдэхүүнийг зах зээлд хуваарилах сүлжээг буй болгож байдал маркетингийн системийн нэг хэсгийг бөөний худалдаа гэнэ.

Энэ өгүүлбэрийн орчуулгад хийгдсэн хэлзүйн хувиргалуудад харьцуулалт хийх гэж оролдлоо.

1. Өгүүлбэрийн бүтцийн хувиргал

- a) Англи жишээ өгүүлбэрийн гол өгүүлбэр эхэндээ байрлаж байхад монгол орчуулгад гишүүн өгүүлбэрийнхээ дараа байрлаж байхаар найруулсан нь өгүүлбэрийн бүтцийн өөрчлөлтөд тооцогдож болохоор байна.
- b). Энд англи хувилбар дахь *which* холбоос нь монгол хэлэнд байнга давтагдах утга заасан *буй болгож байдал* гэсэн үйт нэрээр дүйж байгаа бөгөөд бүтцийн хувьд тодотгол гишүүн өгүүлбэр нь тодотгуулж буй **маркетингийн системийн нэг хэсэг** гэдгийн өмнө орж орчуулагдаж байна. Ингэхлээр энд өгүүлбэрийн бүтцийн хувиргал хийгдлээ гэж үзэж байна.
- c) *Goods* нь англи хувилбар дээр *of* угтварын шууд тусагдахууны үүрэг гүйцэтгэж **бараа бүтээгдэхүүний** хэмээн харьялахын тийн ялгалаар хувирч байхад, монгол хувилбарт **бараа бүтээгдэхүүнийг** гэж заахын тийн ялгалаар хувирах болж байна.
- d) *to be* үйл үгэнд шууд тусагдахуунаар өртөж буй нэрлэхийн тийн ялгал дээр буй *part* хэмээх нэр үгийг монгол хэлэнд **нэг хэсгийг** хэмээн заахын тийн ялгалаар хувиргалаа.
- e). Англи хэлэнд нэр үг нэр үгээ тодотгож болдог. Жишээ нь *bus station*, *aviation weather*, *school bus* гэх мэт. Энэ тохиолдолд хоёр нэр үг хоёулаа нэрлэхийн тийн ялгалд байж болдог. Монгол хэлэнд эхний нэр үг харьялахын тийн ялгалаар хувирч дараагийн нэр үгээ тодотгодог. Жишээ нь *автобусны зогсоол*, *нисэхийн цаг уур*, *сургуулийн автобус* гэх мэт. Үүнтэй адил аар жишээ өгүүлбэрт буй *marketing system* нь монгол хэлэнд **маркетингийн систем** гэж орчуулагдана.
- f). *Provide* үйл үг *channels* гэсэн шууд тусагдахуун авч байхад энэ нь монгол хэлэнд **сүлжээг** хэмээн заахын тийн ялгалаар хувирч байна.
- g). Англи хэл нь тоогоор зохицон хэлбэрждэг хэл. Харин монгол хэлэнд ихэнх тохиолдолд олон тоог хэрэглэхээс зайлсхийдэг. Үүнийг баримталж *goods* гэж олон тоогоор хэлбэржсэн нэр үгийг монгол хэлэнд бараа бүтээгдэхүүн гэж нэг тоогоор хэлбэржүүлж орчууллаа. Мөн үүнтэй нэг адил *channels* гэдэг олон тоон дээр байгаа үгийг **сүлжээ** хэмээн нэг тоогоор хувиргалаа. Энд тус хоёр хэлний тооны айн зөрөө гарч байна.

2. Орхих хувиргал

The marketing system-ийн хувьд *system* гэдэг нэр үг тоологдог үг тул ерөнхий утга зааж олон тоон дээр хэрэглэгдээгүй бол ямар нэг ялгац гишүүнгүй байж болохгүй. Маркетингийн систем нь салбарынхаа хувьд нэг тодорхой бүхэл зүйл учраас *the* ялгацтай хамт хэрэглэгдэж байна. Харин монгол хувилбарт *the* ялгац гишүүн нь ямар нэг тодотгох утга

гаргах шаардлагагүй, маркетингийн систем нь оноосон нэрнээсээ тодорхой байгаа тул орхиж орчууллаа.

Солих хувиргалт

a) Англи хэлийг нэршиэн хэл гэж үздэг байхад монгол хэл үйлшиэн хэл байдаг нь тогтолцооны бас нэг том ялгаа юм. Жишээ нь гишүүн өгүүлбэрийн тусагдахуун *channels*, түүний гүйцэвэр *of distribution of goods to market*-ын хувьд монгол хэлэнд хэлзүйн хувиргалт хийж орчуулах шаардлага гарч буй бөгөөд энд *distribution*-ыг *хуваарилах* гэсэн үйл үгээр сольж орчуулбал монгол хэлэнд найруулгын болоод хэлзүйн хэлбэржилтийн хувьд төгс өгүүлбэр болж байна. Энд бид үгсийн сангийн хэрэглэгдэхүүнийг солих аргыг хэрэглэлээ.

Ялгааг харна уу:

Channels of distribution of goods to market – бараа бүтээгдэхүүнийг зах зээлд хуваарилах сүлжээ

Өгүүлбэрийн гишүүдийн байр солих хувиргалт

- a). Гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн *provides* нь англи өгүүлбэрт өгүүлэгдэхүүн *which* –ийн ард, тусагдахуун *channels*-ийн өмнө байрлаж байгаа бол монгол орчуулгад монгол хэлний өгүүлбэрийн бүтцийн дагуу тусагдахууныхаа ард байрласан байна.
- b). Гол өгүүлбэрийн тусагдахуун *part of marketing system* нь англи өгүүлбэрт үйл үгийн ард байрлаж байгаа бол монгол орчуулгад өгүүлэгдэхүүн *бооний худалдаа*-ны өмнө байрлаж байна.

4. Нэмэх

Англи хувилбарт буй *part, goods, provides* зэрэг үгийг монгол хэлэнд орчуулахад утгын холбоог бодолцож үг нэмж дэлгэрүүлэх шаардлагатай байна.

- a) Жишээ нь *part* гэдэг үгийг монгол хувилбарт *хэсэг* гэдэг ганц үгээр орчуулахад утга гүйцэд гарахгүй, найруулгын хувьд доголдоод байна. Иймд нэг зүйлийг бүрэлдүүлж буй олон зүйлийн *нэг хэсэг* гэж орчуулбал утга бүрэн бууж байна. Англи хэлэнд *part of something* гэдэг хэллэг ч мөн ийм л утгатай юм.
- b) Үүнтэй адил *goods*-ыг зөвхөн бараа гээд орхиход монгол хувилбарт мөн өгүүлбэрийн утга дутаад байна. Иймд *бараа бүтээгдэхүүн* гэсэн хоршоо үг авбал бүрэн утга илэрхийлж чадаж байна. Гэвч зарим тохиолдолд дангаар нь *бараа* гэж орчуулах тал бий. Жишээ нь *goods and service* гэсэн холбоо үгийг монгол хэлэнд *бараа, үйлчилгээ* гэж орчуулж хэвшсэн байна.
- c) *Provide* үйл үг нь монгол хэлэнд тусагдахуунаасаа хамааран *хангах, үзүүлэх, бий болгох, огөх* зэрэг утгыг гаргадаг. Мон судар толь бичгийн орчуулгаас харвал *support, service* зэргийн хувьд *бий болгох, огөх* гэсэн утгыг оногдуулжээ. Энэ өгүүлбэрт *provides* энгийн одоо цагаар хэлбэржсэн

байгаа тул монгол хувилбарт *бий болгоож байдаг* гэж байнга үйлдэгдэж байдаг утгыг тодотгон гаргаж орчуулахад утга дүйж байх шиг санагдана.

Дүгнэлт

Орчуулгад хэрэглэдэг хэлзүйн хувиргалын аргыг англи монгол хэлний тодотгол гишүүн өгүүлбэр дээр нэг өгүүлбэрээр жишээ авч харьцуулан тайлбарлахыг оролдоход дараах зүйлүүд ажиглагдаж байна.

1. *Adjective clause* буюу *тодотгол гишүүн өгүүлбэр* нь гол өгүүлбэрийнхээ

аль нэг нэр үгийг тодотгон угсруулах аргаар холбогдож, тодотгуулагч тодотгогчийн харилцаанд суурилж байдаг нь англи монгол хэлний хувьд төстэй байна.

2. Монгол хэлний тодотгол гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйлийн тодосгон холбох нөхцөл бүхий үйл үг, эсвэл харьцааны нэрээр илэрч, харьяалахын тийн ялгалаар, үндсээрээ, эсвэл *гэ+үйлийн* тодосгон холбох нөхцөл гэсэн хэрэглүүрээр хэлбэржин холбогдог байхад англи хэлний adjective clause нь гол өгүүлбэртэйгээ захирах холбоос болох *who, which, that, whose, where* зэргээр холбогдож байдаг нь хэлзүйн тогтолцооны хувьд ялгаатай болохыг харуулж байна.

3. Эдгээр холбоос нь тодотгол гишүүн өгүүлбэрийг гол өгүүлбэрийн тодотгуулагч үгтэй холbon, гишүүн өгүүлбэртээ ямар нэг гишүүний үүргийг гүйцэтгэдэг. Байрлалын хувьд тодотгуулагч үгтэйгээ ойр байдаг бөгөөд өгүүлбэрийн дунд, юмуу адагт байрлаж болдог. Харин монгол хэлэнд тодотгол гишүүн өгүүлбэр заавал тодотгуулагчийнхаа өмнө байрладаг нь тогтолцооны том ялгаа болно.

4. Эдгээр холбоос үгийн (*who, which, that, whose, where*) дүйцэл монгол хэлэнд байхгүй тул гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүний үйл үгийн хэлбэржилтээс хамааран ихэвчлэн үйлт нэрийн *-даг, дэг, дог, дог* зэрэг үйлийн давталт заасан нөхцөл, *-сан, сэн,сон,сон* зэрэг өнгөрсөн хэлбэр заасан нөхцөл, *-аа, ээ, оо, oo* зэрэг үргэлжилсэн хэлбэр заасан нөхцөл, *гэ+үйлийн* тодосгон холбох нөхцөл, эсвэл нөхцөлт үйлийн *-ж, -ч-гээр* төгссөн хэлбэрийн дараа орсон үйлт нэрийн хэлбэрээр дамжин орчуулагдаж байна.

Эндээс дүгнэхэд зөвхөн нэг өгүүлбэр орчуулахад л хэлзүйн тогтолцооны болон найруулгын талаас нэлээд хэдэн хувиргалт хийх шаардлагатай болж байгаа нь төрөл бус хэлнүүдийн тогтолцоо хэр ялгаатай байдгийг харуулж байна.

Ашигласан ном зүй.

1. Англи Монгол толь, Мон судар, УБ, 2006
2. Г.Аким, “Орчуулгын санг уудлахад” Уб, 1984
3. Д.Гүн-Үйлс, “Орчуулга, найруулга зүй” Уб, 2008
4. Д.Дашдаваа, “Орчуулгын зарим асуудал” УБ, 1977
5. C.E.Eckersley and J.M.Eckersley, ‘Comprehensive English grammar’, Longman, 1993
6. R.L.Miller, ‘Economics’ Scribner Publishing, NY, London, 1988
7. “Нэр томъёо судлал” хурлын эмхтгэл, УБ, 1997
8. “Орчуулгын онол практикийн тулгамдсан асуудлууд” хурлын эмхтгэл, МУИС, ОУХДС, УБ, 2007
9. Ц.Оюун, “Зөв бичгийн дүрмийн тогтолцоот хураамж” УБ, 2004
10. A.Oshima, A.Hogue, ‘Writing Academic English’ NY, 1981
11. Oxford advanced learner’s dictionary, Oxford University Press, 2005
12. Ц.Сүхбаатар, “Монгол хэлний найруулга зүй”, УБ, 1998
13. Д.Төмөртогоо нар, “Та заавал унших монгол хэлний сурх бичиг”, УБ, 1998
14. Ц.Цэдэндамба “Орчуулгын үндэс” УБ, 1979
15. Д.Цэрэнпил, Р.Кулман, “Mongolian grammar”, УБ, 2005